



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2-р баг,  
Утас/Факс: (976) 7033 3141, И-мэйл: arkhangai@audit.gov.mn  
Вэб сайт: www.audit.mn

2018.02.22 № 73

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн газрын төсвийн захирагчийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Цагдаагийн газрын төсвийн захирагчийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагдаагийн газрын төсвийн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон ичлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР



## ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙГДСЭН АУДИТЫН ТАЙЛАН

### АРА-2018/151/СТА-ТШЗ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

**Д.Уламбаяр**  
Архангай аймаг дахь Төрийн  
аудитын газрын дарга, тэргүүлэх  
аудитор  
Утас: 70333141

**Т.Байгалмаа**  
Архангай аймаг дахь Төрийн  
аудитын газрын хэлтсийн дарга  
бөгөөд аудитын менежер  
Утас: 70332860

**Ж.Мөнгөншагай**  
Санхүүгийн аудитын багийн  
Ахлах аудитор

**Хаяг:** Архангай аймаг,  
Эрдэнэбулган сум. Аймгийн  
ЗДТГ-ын байр "А" корпус, 3  
давхар зүүн жигүүр.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2018 оны 02 дугаар сарын 23

Хавсралт 1: Агуулга  
Хавсралт 2: Аудитын тайлан  
Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан  
Хавсралт 4: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн  
тайлан

## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Материаллаг байдлын суурь
10. Завсрын аудитын талаар
11. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Аудитын санал дүгнэлт
15. Аудитлагдсан санхүүгийн тайлан

**1.Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2-д заасан Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайланд АРА-2018/151/СТА-ТШЗ кодтой баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн төсвийн байгууллагын НБББББ-ийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын үүрэг юм.

Уг байгууллагын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 10-аас 2018 оны 02 дугаар сарын 24-ны хооронд хийж, аудитын тайланг 2018.02.14-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ахлах аудитор Ж.Мөнгөншагай хариуцаж хэрэгжүүлэв.

Цагдаагийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018.01.25-нд аймаг дахь төрийн аудитын газарт аудит хийлгэх хүсэлтээ 2018.01.25-ны өдрийн 35/212 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**2.Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Цагдаагийн газрын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Татварын ерөнхий хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

**3.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Цагдаагийн газар нь 2017 онд:

1. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар үр дүнг дээшлүүлэх
2. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх зүйн орчыг шинэчилж, сургалтын үр дүнг дээшлүүлэх
3. Алба хаагчдын ажилын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах” гэж байгууллагын зорилтыг тодорхойлсон байна. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1 “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Цагдаагийн газрын дарга нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Цагдаагийн газар нь Хууль зүйн яамны төсвийн багцаас санхүүжиж, санхүүжилт нь сумын төрийн сангаар дамжин олгогдсон.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

#### **4.Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Acolous” програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **5.Дотоод хяналт:**

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой.

Цагдаагийн газар нь дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон.

#### **6.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Цагдаагийн газрын төсвийн шууд захирагч нь 2017 онд урсгал зардалд 1,878.7 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснийг бүрэн авч, төсөвт газрын өөрийн оролгоор 57.2 сая төгрөг төлөвлөгдөж 63.0 сая төгрөгийг төвлөрүүлэн тайлант онд 17.5 сая төгрөгийг дээд шатны төсвийн дансанд төвлөрүүлэн ажилалсан байна.

Мөн тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар Засаг даргын а/260 тоот захирамжаар 30.0 сая төгрөгийг Цагдаагийн байгууллагын тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, АИТХурлаас ГХУСЗардалд 4.1 сая төгрөгийг, Эрдэнэбулган сумын ИТХурлаас ГХУСЗардалд 2.4 сая төгрөгийг, Сонгуулийн зардалд 15.2 сая төгрөгийг тус тус хүлээн авч зориулалтын дагуу зарцуулан тайлагнасан байна.

#### **7.Шилэн дансны мэдээлэл:**

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 2017 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл,

санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2017 оны 10 дугаар сард нийцлийн аудит хийгдсэн бөгөөд тайлант хугацаанд мэдээллийг бүрэн байршуулсан байна.

### 8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 3 горим, сорил гүйцэтгэв.

### 9. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,081.4 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь 20.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

### 10. Завсрын аудитын талаар

Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар дараах зөрчлүүд илэрсэнг тайлант онд нь зөрчлийг нь арилгуулсан байна.

1. Ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн, цаашид ашиглах боломжгүй болсон 0.7 сая төгрөгийн 2 ширхэг зургийн аппарат тайлан балансад бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.4-д “... **үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах**” гэсэн заалтыг зөрчсөнд зөвлөмж хүргүүлэн зөрчлийг арилгуулан ажилласан байна.

### 11. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 1,191.8 сая төгрөгийн цалингийн зардал, 13.1 сая төгрөгийн тээвэр шатахууны зардал, 32.1 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал /УИХ-ы 67-р тогтоол, Засгийн газрын 52-р хурлын тэмдэглэлийн дагуу 107 ажилтанд олгосон тэтгэмж/, шагнал урамшууллын зардал зэрэг нийт 64.6 сая төгрөгийн зардлын дансанд, 1,192.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө болон авлага, өр төлбөр бусад дансын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Байгууллагын аж ахуй материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл их байгаа нь тайлант оны эцэст Цагдаагийн ерөнхий газраас үэнэ төлбөргүй шилжүүлэн ирсэн бараа материалуудтай холбоотой байна. Мөн тусгай зориулалтын материал, бусад хангамжийн материалын дансаны үлдэгдэл их хэмжээтэй байгаа байгууллагын үйл ажилагаатай холбоотой материалууд байна.

Тайлант онд орон нутгаас 91.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй олгосон байна.

### 12. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 3 чиглэлээр 3 эрсдэлтэй асуудалд 3 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн ажиллахад зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлэх зөрчил илрээгүй..

### 13.Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

2018 онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг завсрын аудитад хамруулан шалгахдаа үндсэн хөрөнгө, төсөвт газрын өөрийн орлого, үндсэн цалингийн зардлыг тусгайлан авч үзнэ.

### 14.Аудитын санал дүгнэлт:

Аудитын явцад илэрсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилгүй тул зөрчилгүй санал дүгнэлт өгөх саналтай байна. Цагдаагийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

### 15.Аудитлагдсан санхүүгийн тайлан:

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>155,356,135.11</u></b>	<b><u>163,748,699.58</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	27,534.74	117,432.24
		27,534.74	117,432.24
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>		
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	6,095,146.81	516,092.30
		6,095,146.81	516,092.30
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		
35110	Тусгай зориулалттай материал	149,233,453.56	163,115,175.04
35130	Эм боох материал	73,045,675.25	76,326,382.25
35130	Эм боох материал	72,775,745.25	75,958,678.25
35300	Бэлэн бүтээгдэхүүн	269,930.00	367,704.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,949,000.00	1,949,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		
35410	Бичиг хэргийн материал	71,530,778.31	77,808,192.79
35410	Бичиг хэргийн материал	3,040,538.00	5,278,558.00
35420	Аж ахуйн материал	4,687,774.34	4,785,454.99
35430	Сэлбэг хэрэгсэл	5,243,239.00	29,739.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	386,080.00

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН АУДИТ

35450	Барилгын засварын материал	3,500.00	8,500.00
35460	Хүнсний материал	1,874,857.52	1,302,276.62
35470	Бусад хангамжийн материал	56,680,869.45	66,017,584.18
35600	Мал амьтад	2,708,000.00	7,031,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,232,668,849.96</b>	<b>2,250,168,292.49</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,232,668,849.96</b>	<b>2,250,168,292.49</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,232,468,849.96</b>	<b>2,249,831,313.36</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,445,051,145.73	2,445,051,145.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	-521,358,443.95	-586,821,441.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	353,466,035.13	464,576,118.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	-217,034,779.30	-269,162,757.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	159,086,444.82	199,485,845.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	-111,362,581.84	-125,992,036.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,505,509.54	70,642,147.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,834,645.29	-46,970,885.77
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	34,765,656.00	34,765,656.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	78,284,565.00	78,284,565.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,100,055.88	-14,027,044.64
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>200,000.00</b>	<b>336,979.13</b>
39301	Програм хангамж	1,651,838.50	1,926,838.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,451,838.50	-1,589,859.37
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,388,024,985.07</u></b>	<b><u>2,413,916,992.07</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>6,000.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>6,000.00</b>	<b>0.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>6,000.00</b>	<b>0.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,388,018,985.07</u></b>	<b><u>2,413,916,992.07</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,388,018,985.07</b>	<b>2,413,916,992.07</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,106,313,662.04	1,106,313,662.04
51101	Өмч: - төрийн	1,106,313,662.04	1,106,313,662.04
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,019,535,775.03</b>	<b>1,045,433,782.03</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,019,535,775.03	1,019,535,775.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	25,898,007.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	262,169,548.00	262,169,548.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,388,018,985.07</u></b>	<b><u>2,413,916,992.07</u></b>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,695,405,524.15</b>	<b>2,107,962,536.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>938,268,424.15</b>	<b>141,295,353.05</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	938,268,424.15	141,295,353.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	71,742,095.07	92,331,169.19
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,105,120.00	47,583,396.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,141,774.00	15,440,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,495,201.07	29,307,673.19
120009	Бусад орлого	866,526,329.08	48,964,183.86
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,757,137,100.00</b>	<b>1,966,667,183.65</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,736,380,100.00	1,821,465,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,736,380,100.00	1,821,465,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,757,000.00	52,587,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,567,000.00	36,605,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,190,000.00	15,202,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	780,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	92,614,783.65
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	00.00	92,614,783.65
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,911,522,638.87</b>	<b>2,081,387,196.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,896,859,281.77</b>	<b>2,030,524,538.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,896,859,281.77	2,030,524,538.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,462,572,980.01	1,500,333,036.76
210101	Үндсэн цалин	876,481,944.00	875,928,614.00
210102	Нэмэгдэл	536,185,308.01	576,997,657.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,160,000.00	.
210104	Урамшуулал	3,038,152.00	.
210105	Гэрээт ажлын хөлс	40,707,576.00	47,406,765.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,276,394.00	31,867,365.74
210201	Тэтгэврийн даатгал	1,637,375.00	1,030,143.00
210202	Тэтгэмжийн даатгал	187,129.00	117,728.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	233,911.00	147,163.00
210204	Ажилгүйдлийн даатгал	46,784.00	29,435.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,171,195.00	30,542,896.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	109,611,426.00	99,068,081.00
210301	Гэрэл, цахилгаан	6,596,416.00	6,829,166.00
210302	Түлш, халаалт	98,523,764.00	90,562,347.00
210303	Цэвэр, бохир ус	4,491,246.00	1,676,568.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	135,553,531.81	141,337,359.05
210401	Бичиг хэрэг	10,299,024.00	13,028,200.00
210402	Тээвэр, шатахуун	113,200,942.00	110,920,493.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,615,299.15	9,665,239.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,438,266.66	2,424,709.35
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	420,722.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,877,995.00

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН АУДИТ

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,943,041.48	19,532,989.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	96,720.00	119,116.00
210502	Хоол, хүнс	19,846,321.48	19,413,873.90
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	28,668,720.00	66,222,977.00
210604	Урсгал засвар	28,668,720.00	66,222,977.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	14,402,200.00	14,938,500.00
210702	Дотоод албан томилолт	14,402,200.00	14,938,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,858,745.00	2,123,145.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000.00	.
210803	Даатгалын үйлчилгээ	193,660.00	607,240.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,306,340.00	960,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	278,745.00	165,000.00
210807	Газрын төлбөр	00.00	390,905.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	92,972,243.47	155,101,084.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	630,000.00	4,731,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	189,560.60	1,250,797.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,152,682.87	149,118,327.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,663,357.10	50,862,658.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	33,293,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	33,293,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,163,357.10	17,569,658.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	17,569,658.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,163,357.10	.
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>783,882,885.29</b>	<b>26,575,340.21</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	7,478,953.62	.
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	677,333.21
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	677,333.21
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	7,478,953.62	-677,333.21
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>791,361,838.91</b>	<b>25,898,007.00</b>

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,821,383,994.00</b>	<b>1,937,077,184.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>64,246,894.00</b>	<b>63,024,784.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	64,246,894.00	63,024,784.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,246,894.00	63,024,784.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,105,120.00	47,583,396.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,141,774.00	15,441,388.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,757,137,100.00</b>	<b>1,874,052,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,736,380,100.00	1,821,465,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,736,380,100.00	1,821,465,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,757,000.00	52,587,000.00

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН АУДИТ

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,567,000.00	36,605,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,190,000.00	15,202,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	780,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,811,196,734.00</b>	<b>1,901,642,284.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,811,196,734.00</b>	<b>1,901,642,284.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,796,533,376.90</b>	<b>1,850,779,626.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,463,223,609.76</b>	<b>1,501,903,200.00</b>
210101	Үндсэн цалин	1,179,454,109.75	1,191,794,800.00
210102	Нэмэгдэл	237,817,500.00	270,316,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,160,000.00	.
210105	Гэрээт ажлын хөлс	39,792,000.01	39,792,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,649,298.99</b>	<b>30,393,100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,048,588.60	1,061,183.00
210202	Тэтгэмжийн даатгал	361,254.21	117,728.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	451,642.44	147,163.00
210204	Ажилгүйдлийн даатгал	90,329.37	29,436.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,697,484.38	29,037,590.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>109,611,426.00</b>	<b>99,118,081.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,596,416.00	6,879,166.00
210302	Түлш, халаалт	98,523,764.00	90,562,347.00
210303	Цэвэр, бохир ус	4,491,246.00	1,676,568.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>119,947,029.15</b>	<b>116,130,435.00</b>
210401	Бичиг хэрэг	11,490,880.00	14,065,970.00
210402	Тээвэр, шатахуун	95,238,920.00	88,281,166.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,179,299.15	9,648,969.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,037,930.00	4,134,330.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>19,637,429.00</b>	<b>23,472,405.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	133,000.00	4,806,832.00
210502	Хоол, хүнс	18,804,429.00	18,037,073.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	628,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36,428,980.00</b>	<b>61,235,760.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,603,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	324,740.00	.
210604	Урсгал засвар	36,104,240.00	59,632,060.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,402,200.00</b>	<b>14,938,500.00</b>
210702	Дотоод албан томиллолт	14,402,200.00	14,938,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,858,745.00</b>	<b>2,558,145.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,000.00	435,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	693,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	960,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	278,745.00	165,000.00
210807	Газрын төлбөр	00.00	304,405.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>774,659.00</b>	<b>1,030,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	566,159.00	.
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	208,500.00	1,030,000.00

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН АУДИТ

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,663,357.10	50,862,658.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	33,293,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	33,293,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,163,357.10	17,569,658.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	17,569,658.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,163,357.10	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,187,260.00	35,434,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,187,260.00	35,434,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,187,260.00	35,434,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,187,260.00	35,434,900.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	10,187,260.00	35,434,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,187,260.00	-35,434,900.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,106,313,662.04	262,169,548.00	1,019,535,775.03	2,388,018,985.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,106,313,662.04	262,169,548.00	1,019,535,775.03	2,388,018,985.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,898,007.00	25,898,007.00
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,106,313,662.04	262,169,548.00	1,045,433,782.03	2,413,916,992.07

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,878,791,400.00	1,866,920,526.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,878,791,400.00	1,866,920,526.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,844,191,400.00	1,834,820,526.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,501,903,200.00	1,501,903,200.00
210101	Үндсэн цалин	1,191,794,800.00	1,191,794,800.00
210102	Нэмэгдэл	270,316,400.00	270,316,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	39,792,000.00	39,792,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,393,100.00	30,393,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,393,100.00	29,037,590.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	101,251,800.00	99,118,081.00
210301	Гэрэл, цахилгаан	8,191,200.00	6,879,166.00
210302	Түлш, халаалт	90,563,700.00	90,562,347.00
210303	Цэвэр, бохир ус	2,496,900.00	1,676,568.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	110,061,600.00	110,019,435.00
210401	Бичиг хэрэг	13,109,200.00	13,108,970.00
210402	Тээвэр, шатахуун	85,642,400.00	85,601,166.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,557,000.00	7,556,969.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,753,000.00	3,752,330.00
2105	<b>Нормативт зардал</b>	15,782,600.00	14,676,405.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,817,000.00	6,816,832.00
210502	Хоол, хүнс	7,465,600.00	7,231,073.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	628,500.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	61,004,000.00	60,648,660.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	263,000.00	
210604	Урсгал засвар	60,741,000.00	60,648,660.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	20,550,000.00	14,938,500.00
210702	Дотоод албан томилолт	20,550,000.00	14,938,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,245,100.00	2,123,145.00
210803	Даатгалын үйлчилгээ	720,000.00	693,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	960,000.00	960,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,100.00	165,100.00
210807	Газрын төлбөр	400,000.00	304,405.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1000000.00	1000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00


ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН АУДИТ

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг	34600000.00	32100000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,600,000.00	32,100,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,878,791,400.00	1,866,920,526.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,821,465,400.00	1,803,895,742.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	57,326,000.00	63,024,784.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,326,000.00	47,583,396.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	15,441,388.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>		
620001	Удирдах ажилтан	129.00	129.00
620002	Гүйцэтгэх ажилтан	01.00	01.00
620003	Үйлчлэх ажилтан	125.00	125.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	03.00	03.00
650010	Гэрээт ажилтан	126.00	126.00
		03.00	03.00

**АУДИТЫН ТАЙЛАН**

**Хянасан:**

Тэргүүлэх аудитор



Д.Уламбаяр

Аудитын менежер



Т.Байгалмаа

**Бэлтгэсэн:**

Ахлах аудитор



Ж.Мөнгөншагай